



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/528

Арвайхээр

**Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг
дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг
эрчимжүүлэх тухай**

Коронавируст халдвар, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” 05 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.18-аас дээш насны иргэдийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтад хамруулах ажлыг эрчимжүүлэх 1 сарын аяныг 2021 оны 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 26-ны өдрүүдэд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсэгт (аймгийн Засаг даргын орлогч С.Ундрах) даалгасугай.

3.Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг эрчимжүүлэх ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврыг сумын хэмжээнд удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжүүлж ажиллахыг сумдын Онцгой комисс, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

4.Вакцинжуулалтыг өдөр тутамд мэргэжил арга зүйгээр хангаж, мэдээ тайланг нэгтгэж, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-д үүрэг болгосугай.

5.Вакцинжуулалтын дүн мэдээ, зохион байгуулалттай холбоотой мэдээлэл, үр дүнгийн тайланг 14 хоног тутамд аймгийн Онцгой комисст танилцуулахыг ажлын хэсэгт (аймгийн Засаг даргын орлогч С.Ундрах) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101119

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны...
дугаар сарын...-ны өдрийн...
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ
ДАРХЛАА СЭРГЭЭХ НЭМЭЛТ ВАКЦИНЖУУЛАЛТЫГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫГ ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч С.Ундрах
Нарийн бичиг: Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын
Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Гишүүд: -Аймгийн Онцгой байдлын газрын дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол соёл, урлагын газрын дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
- Арвайхээр сумын Засаг дарга
- Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга
- Өвөрхангай аймаг дахь Улаан загалмайн хороо
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн
- Онцгой байдлын газрын гамшиг, эрсдлийн удирдлагын мэргэжилтэн

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны
 дугаар сарын-ны өдрийн дугаар
 захирамжийн хоёрдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ДАРХЛАА СЭРГЭЭХ НЭМЭЛТ
 ВАКЦИНЖУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага
Нэг. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг эрчимжүүлэх зохион байгуулалтын талаар				
1.1.	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг 1,2 дугаар тун, дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын явцын судалгааг эцэслэн сум бүрээр нэгтгэж гаргах	10 сарын 26-ны дотор	С.Ундрах	Эрүүл мэндийн газар Сумдын ЗДТГ
1.2.	Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчлөөд эдгэрсэн болон 1 тун вакцитай иргэдийн вакцинжуулалтын хугацааны талаар судалгаа хийж, аймгийн Онцгой комисст танилцуулах	10 сарын 30-ны дотор	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
1.3.	Дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтад хамруулах төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллага, худалдаа үйлчилгээний төвүүд, аймаг, сумын хүнс, бараа, түүхий эд, техникийн зах дээр бизнес эрхэлж буй иргэд, тэдгээрт ажиллагсадын тоо бүхий жагсаалт гаргаж ажлын хэсгийн гишүүдэд хариуцуулан хуваарилах	10 сарын 26-ны дотор	С.Ундрах	Эрүүл мэндийн газар Сумдын ЗДТГ
1.4.	Ажлын хэсгийн гишүүд өөрт хуваарилагдсан сум, байгууллагын удирдлагуудтай холбогдож байгууллага, нэгж бүрээр вакцинд хамрагдах ажилтан, албан хаагчдын нэрсийг гаргуулж, вакцинд хамруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл өгөх, хамрагдалтыг эрчимжүүлж вакцины явцын мэдээллийг өдөр бүр хүлээн авч ажлын хэсэгт тоон мэдээлэл ирүүлэх	Өдөр бүр	М.Золзаяа Ажлын хэсгийн гишүүд	Сумдын ЗДТГ
1.5.	Аймгийн хэмжээний эрсдэлт бүлгийн хүн амд мэдээлэл хүргэж вакцинжуулах ажлыг зохион байгуулах - 55-аас дээш насны өндөр настан - Малчид, тариаланчид - Архаг, суурь өвчтэй хүмүүс - Дархлаа дарангуйлагдсан иргэн	11 сарын 05 -ны дотор	Эрүүл мэндийн газар Сумдын Онцгой комисс	Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүд Хөдөлмөр халамж үйлчилгээний газар Хүнс хөдөө аж ахуйн хэлтэс Ахмадын холбоо



	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд - Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэд - Эмзэг бүлгийн иргэд (гэр оронгүй, ядуу) 	10 сарын 30-ны дотор	Эрүүл мэндийн газар,	Сум, өрхийн эрүүл мэндийн төв
1.6	Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчлөөд эдгэрсэн болон 1 тун вакцитай иргэдийн вакцинжуулалтын хугацааны талаар судалгаа хийж, танилцуулах	10 сарын 26-ны дотор	Эрүүл мэндийн газар Онцгой байдлын газар	Аймгийн Засаг даргын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Монголын нэгдсэн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга
Хоёр. Олон нийтэд хүргэх мэдээлэл сурталчилгааны талаар				
2.1	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ач холбогдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх график төлөвлөгөө гаргах /ямар мэдээллийг ямар сувгаар, ямар хугацааны давтамжтайгаар, ямар хэлбэрээр явуулахыг нарийвчлан боловсруулах/	11 сарын 20-ны дотор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Аймгийн Шуурхай штабын Мэдээлэл, технологи, харилцаа холбооны баг Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн	Монголын сэтгүүлчдийн нэгдсэн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга
2.2.	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ач холбогдлын талаарх мэдээлэл дамжуулах цахим хуудас, хэвлэл мэдээллийн байгууллага, албан байгууллагуудын жагсаалт гаргах, мэдээлэл дамжуулах зураглал гаргах, хамтран ажиллах байгууллагуудад мэдэгдэх	Өдөр бүрийн график төлөвлөгөөний дагуу	Эрүүл мэндийн газар Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс
2.3	Мэдээлэл сурталчилгааны мессеж, зурган болон хөдөлгөөнт инфографикын эх бэлтгэх, мэдээллийн агуулгад боловсруулалт хийж дамжуулахад бэлэн болгох	Тухай бүр	Эрүүл мэндийн газар Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн	
2.4	Боловсруулсан мэдээллийг цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчлах			



2.5.	Вакцинжуулалтын талаарх олны танил, нас насны төлөөлөл бүхий хүмүүсийн жагсаалт гаргаж, иргэдтэй холбогдож дүрст бичлэгт орох бэлтгэлийг хангуулах, ярианы агуулгыг бэлтгэн, урьдчилан хүргүүлэх, дүрст бичлэгийг бэлтгэх	10 сарын 30-ны дотор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Аймгийн Шуурхай штабын Мэдээлэл, технологи, харилцаа холбооны баг	Эрүүл мэндийн газар БОЭТ
2.6.	Улсын хэмжээнд цацагдаж буй сурталчилгааны мэдээллүүдийг ангилан төрөлжүүлж цувралаар олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах	10 сарын 26-аас эхлэн 11 сарын 20-ныг хүртэл	Эрүүл мэндийн газар	Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн
2.7.	Өвчлөөд эдгэрсэн хүмүүсийн яриаг цахим хуудас, фейсбүүк, твиттер, инстаграмаар зураг хуудас, урт, богино хугацааны видео шторк хэлбэрээр сурталчлах	11 сарын 20-ны хүртэл	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн Эрүүл мэндийн төв БОЭТ
1.7.	Идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудын захирал, тэргүүнүүдэд тусгайлан мэдээлэл хүргүүлж гишүүд, дэмжигчиддээ вакцинжуулалтын ач холбогдлын талаарх яриа таниулаг хийх, вакцинжуулалтад хамруулах ажлыг боломжит хэлбэрээр зохион байгуулах	10 сарын 30-ны дотор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс	Засаг даргын дэргэдэх хэлтэс албадыг дарга нар Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын дарга, удирдах зөвлөлүүд
2.5.	Нийт ажилтан, албан хаагчдаа дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтад хамруулсан төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчлах	11 сарын 01-ны дотор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар	Хэлтэс албад, албан байгууллагууд
2.6.	Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтыг ач холбогдлын талаарх цахим сургалт зохион байгуулах	11 сарын 01-ны дотор	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд
2.7.	Үүрэн телефоны операторуудаар илгээх масс мессеж (160 тэмдэгтэд багтаах)-ийг бэлтгэх, түгээх	11 сарын 20 хүртэл	Эрүүл мэндийн газар	Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн
2.8.	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ач холбогдлын талаарх инфографикийг гудамж, талбайн Лед дэлгэц, сурталчилгааны самбараар сурталчлах	11 сарын 20 хүртэл	Эрүүл мэндийн газар	Аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн
2.10	Өрхийн эрүүл мэндийн төвөөс вакцинд хамрагдах хугацаа болсон иргэдэд утсаар мэдээлэл өгөх	11 сарын 20-ны дотор	Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд	